

# МОНГОЛЫН МЭДЭЭ

2018.05.10. Пүрэв. №093 (4943)

ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ

Хүн ам 3,203,907...  
ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр  
Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



- “Дэлхийн сонины холбоо”-ны гишүүн
- 1999 оны шилдэг чөлөөт хэвлэл
- 2002 оны шилдэг хэвлэл
- 2013 оны Монгол Улсын шилдэг сонин
- Best of Mongolia-2016 - Оны шилдэг сонин

[www.dardas.mn](http://www.dardas.mn)  
[facebook.com/dardas.mn](https://facebook.com/dardas.mn)  
[twitter.com/MMdardas](https://twitter.com/MMdardas)  
[mongoliinmedeesonin@gmail.com](mailto:mongoliinmedeesonin@gmail.com)

20 дахь жилдээ

Дугаарыг эрхэлсэн Балжирын ӨНӨРТОГТОХ

ДОТОР НҮҮРТ

V НҮҮРТ:

Ч.ХҮРЭЛБААТАР:  
2019 ОНД ЭДИЙН  
ЗАСГИЙН  
ӨСӨЛТИЙГ  
ХАНГАНА

...Төсвийн алдагдлыг  
бууруулах бод-  
лого барьж байгаа.  
Алдагдлыг шууд  
тэглэсэн бодлого  
баримталж болохгүй.  
Төсвийн алдагдлыг  
бууруулах талаар тоо-  
цоолж байна. Гэхдээ  
өнгөрсөн дөрвөн  
жилийн турш агшсан  
эдийн засгийг тэлэх  
шаардлагатай...

ҮЗЭЛ БОДОЛ


## АЛДААНД ӨГӨХ ТАЛАРХАЛ



Б.ӨНӨРТОГТОХ  
baljirunurtogtokh@gmail.com

Соошл орчинд өөрийн буруу үйлдлээс болж олон хүн шүүмжлэлийн бай болдог. Гэвч тэд бол өнөөгийн нийгмийн тусгал. Ямар нийгэм бүтээснээ бид тэднээс олж харж байгаа хэрэг. Төрийн байгууллагын үнэн төрх, улс төрийн намуудын өнөөгийн төрх, улс орны хөгжлийн бодит байдлыг “илчилсэн” тэр хүмүүст баярлалаа. Доорхи зураг, тайлбар хоёроос нэгийг бодож, хоёрыг тунгаах эрх та бидэнд бий.

Үргэлжлэл нь III нүүрт



ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

С.Даваасүрэн: Төр ажлаа хийж байна  
Н.Энхтуяа: Төрөөс нэг уут гурилын мөнгө гуйгаагүй



Ц.ЧАНДМАНЬ-ЭРДЭНЭ  
ts.chandmanierdene@gmail.com

Өчигдөр НМХГ-аас 100 айл орчмын газарт хууль бусаар үйл ажиллагаа явуулж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг албадан нүүлгэх ажлыг зохион байгуулав. Уг ажлыг бид сурвалжилсан юм. Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлгийн баруун талд Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын зөөврийн пост байрлуулжээ.

Уг постод дүүргийн мэргэжлийн хяналтын байцаагч нар байрлаж ажиллах бөгөөд Сүхбаатар дүүргийн 9, 10, 11, 12 дугаар хорооны нутаг дэвсгэр 100 айл, Цагдаагийн гудамжид байрлах 145 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй газар ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, ил задгай худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэдийн худалдаа үйлчилгээг албадан чөлөөлүүлэхээр ажилласан юм.

Үргэлжлэл нь VI нүүрт

АУГАА ЭХ ОРНЫ ДАЙНЫ ЯЛАЛТ-73 ЖИЛ

## ЯЛАЛТЫН БИДНИЙ Ч БАЯР

–Амиа алдсан хүн бүхэн бидний зүрх сэтгэлд мөнх орших болно–



Б.ДАВААХҮҮ  
Davaakhuu0128@gmail.com

ОХУ-ын нийслэл Москва хотын Улаан талбайд өчигдөр 1941-1945 оны Аугаа эх орны дайны 73 жилийн ойд зориулсан цэргийн сүрт жагсаал боллоо. Жагсаалд цэргийн 13 мянга гаруй бие бүрэлдэхүүн оролцсоноос гадна тус улс армийн өнөөгийн

дүр төрхийг нь тодорхойлох 159 зэвсэг техникээ танилцууллаа. Мөн агаарын 77 хөлөг нисэх хүчнийг төлөөлж, үзэгчдийн мэлмийг баясгасан бол энэ онд шинээр зэвсэгт хүчинд нийлүүлж буй байлдааны “Терминатор” машин, тав дахь үеийн сөнөөгч “Су-57”, “Кинжал” цогцолбортой “МиГ-31К” нисэх онгоц, түүнчлэн олон зориулалттай робот техникийн цогцолборууд болон нисгэгчгүй онгоцуудыг анх удаа дэлгэж харуулсан юм. Ёслолын жагсаалыг Хуурай замын цэргийн ерөнхий командлагч, хурандаа генерал Олег Салюков командлав.

Үргэлжлэл нь VII нүүрт

60 ширхэг  
30 ширхэг  
Өтгөн ханд

Танай гэр бүлийн Эрүүл байх үндэс

Эртний Энэтхэгийн сударт барагшуныг өдөр тутам тогтмол хэмжээгээр хэрэглэж чадвал 100 наслах боломжтой хэмээжээ.

Барагшун нь Түвд, Энэтхэг, ОХУ, Узбекистан болон Монгол орны Алтай, Хангай, Хэнтийн нуруудын 2500-аас дээш метрийн өндөрт хадны ан цав, түүний гадаргаас нарны элчинд халж, шүүрэн гардаг байгалийн идэвхтэй шимт бүтээгдэхүүн юм. Монгол Алтайн нурууны барагшун нь дэлхийн бусад орны барагшунтай харьцуулахад хүчлийн агуулагдах хэмжээ хамгийн өндөр буюу 13 хувийн агууламжтай байгаа юм.

Япон улсын эрдэмтдийн судалгаагаар гүүний саам болон барагшунаас өөр ямар ч бүтээгдэхүүнд ийм олон төрлийн эрдэс бодис, амин хүчлүүд нэг дор агуулагдаагүй болох нь тогтоогджээ. Барагшун нь бие махбодийн дархлааг сайжруулах, бодисын солилцоог зохицуулах, халдваргүйжүүлэх, үрэвслийн эсрэг, эд эсийн нөхөн төлжилт, цус төлжилтийг дэмжих, ерөнхий биеийн байдлыг сайжруулах үйлчилгээ үзүүлэхээс гадна яс хугарсан үед бороололтыг дэмжих, үрэвсэл шархлаат өвчний үед нөхөн төлжилтийг сайжруулах, ходоодны хүчлийг тэнцвэржүүлэх, өвдөлт намдаах, нөхөн сэргээх, үрэвслийн эсрэг, мэс заслын дараа хэвийн байдалдаа эргэн ороход, хими эмчилгээний таагүй үр дагавараас хурдан гарахад өндөр үйлчилгээтэй юм.

- Хайрцагтаа 60 ширхэг шингэн барагшун  
-50000 төг /1 сарын хэрэглээ/
- 100 граммтай найруулж уух өтгөн барагшун  
-25000 төг
- Үе мөчний наалт  
-2500 төг /уутандаа 2 ширхэг/

УТАС:  
99013323,  
94413323,  
99945545



МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Хугацаа нь дууссан бэлэн гоймон худалдаалж байжээ

Г.САНЖААХАНД

“Вьетнам засварын газруудад хугацаа нь дууссан бэлэн гоймон, хоол амтлагч тарааж, агуулахад хадгалж байна” гэх мэдээлэл нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт иржээ. Мэдээллийн дагуу Баянзүрх дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Консулын 18 гудамжинд байрлах “Баруун хөшөөт” компанийг шалгажээ. Шалгалтаар хадгалах хугацаа нь дууссан их хэмжээний бэлэн гоймон, хатаасан жимс, хоол амтлагч, хоёр төрлийн бохь зэрэг хүнсний бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангаагүй агуулах, чингэлэгт хадгалж байсан зөрчил илэрчээ. Тиймээс хугацаа нь дууссан дээрх хүнсний бүтээгдэхүүнийг битүүмжилсэн байна. Мөн Зөрчлийн тухай хуулийн 6.15 дугаар зүйлийн 3.1 дахь хэсэгт зааснаар зөрчлийн хэрэг нээсэн бөгөөд хяналт шалгалт үргэлжилж байгаа аж.

Сурагчдаас төлбөр, хураамж авахыг хориглолоо

Г.САНЖААХАНД

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа сурагчдаас төлбөр, хураамж, хандив авахыг хориглосон шийдвэр гаргажээ. Тодруулбал, сурагчдын зөвлөл, эцэг, эхийн зөвлөлийн үүсгэл санаачилга нэрээр мөнгө татаж, багшид бэлэг өгөх, эцэг, эхэд санхүүгийн дарамт учруулахгүй байхыг сануулсан байна. Түүнчлэн анги дэвших болон улсын шалгалт, элсэлтийн ерөнхий шалгалттай холбоотойгоор хичээл заадаг багш нар суралцагчдад төлбөртэй давтлага өгөх, ном, гарын авлага, материал худалдан авахыг шаардах, шахахыг хориглосон аж. Нийслэлийн Боловсролын газар болон 21 аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга нарт хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах юм байна. Улмаар ерөнхий боловсролын сургуулийн анги танхим, ариун цэврийн байгууламж, гадна талбайн засвар, үйлчилгээг энэ оны зургадугаар сарын 18-ны дотор дуусгахаар зохион байгуулах, боловсролын байгууллагын ногоон байгууламж, орчны тохижилт, аюулгүй байдалд онцгой анхаарал хандуулж ажиллахыг анхааруулжээ.

ММ-ИЙН ТОДРУУЛГА

# Р.ЭНХТУЯА: Таны бэлэглэсэн цус гурван хүнд амьдрал бэлэглэнэ



Г.САНЖААХАНД  
xandaa1995@gmail.com

*Энэ сарын 03-ны өдөр нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн Дунжингарав салбарт цус цуглуулах салбар төв шинээр нээлтээ хийсэн билээ. Энэ талаар ЦССҮТ-ийн донор зохион байгуулалтын тасгийн их эмч Р.Энхтуяагаас тодрууллаа.*

-Дунжингарав худалдааны төвд цус цуглуулах шинэ төв нээлтээ хийсэн. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?

-Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс санаачлан Эрүүл мэндийн сайдын тушаалаар сар бүрийн 03-ны өдрийг “Цусаа бэлэглэх өдөр” болгон тэмдэглэн өнгөрүүлж байхаар болсон. Энэ удаагийн цусаа бэлэглэх өдрийг Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн Дунжингарав салбарт тэмдэглэн өнгөрүүллээ. Түүнчлэн “Жи Си Ай капитал” байгууллагын дэмжлэгтэйгээр байгуулсан “Дунжингарав” цус цуглуулах шинэ төвийн нээлтийг хийлээ. Уг төв нээлтээ хийснээс хойш

НИЙГЭМД ЦӨӨН МӨРӨӨР

•Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын нэгдүгээр 12 жилийн 9а ангийн сурагчид өөрсдийн санаачлагаар хаягдал дутуй ашиглан шат хийжээ. Тодруулбал, тус аймагт ойрхон байрладаг "Бурхийн рашаан" гэх ходоод дотрын рашаан руу хүүхэд, хөгшид очиход хүндрэлтэй байдаг аж. Энэ хэцүү байдалд нь туслах үүднээс бууж, өгсөх шат хийсэн байна.

•Энэ сарын 07-ны байдлаар Архангай аймгийн Хотонтын сум дамнасан голомт /Хотонт, Өгийнуур/, Ихтамир сум, Өвөрхангай аймгийн Өлзийт, Зүүнбаян-

Улаан сум, Төв аймгийн Жаргалант сум гэсэн нийт гурван аймгийн зургаан суманд хорио цээрийн дэглэм хэрэгжиж байгаа аж.

•“Miss World 2018” тэмцээний тов зарлагдаж, энэ жил арваннэгдүгээр сарын 09-нд БНХАУ-ын Саньяа хотноо зохион байгуулахаар болжээ. Тиймээс “Дэлхийн Мисс” тэмцээнд эх орноо төлөөлөн оролцох сонирхолтой бүсгүйчүүдийг бүртгэж эхэлсэн байна.

•Яармагийн шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах төслийн хүрээнд

хүмүүс юуг анхаарах ёстой вэ. Хориглох зүйл байдаг уу?

-Өөрийгөө эрүүл гэж бодож байгаа 17-60 хүртэлх насны 45-с дээш кг жинтэй иргэн та цусаа өгөх боломжтой. Цус өгөхөд түр буюу бүр хориглох заалт гэж байдаг. Тодруулбал, элэгний В, С вирусгүй хүмүүс цус өгөх боломжтой. Цус өгөхийн өмнө өөх тостой хоол хориглодог. Мөн доод тал нь зургаан цаг унтаж амарсан байх хэрэгтэй. Цусаа өгөхөөр ирсэн хүмүүс донорын эрүүл мэндийн карт бөглөж эмчтэй ярилцлага хийж бэлтгэл хангасан бол цусаа өгдөг.

-Хүмүүс цусаа өгч байх нь зөв үү. Нэг хүнээс хэдий хэмжээний цус авдаг юм бэ. Цусаа өгснөөр хэдэн хүнд амьдрал бэлэглэх боломжтой гэсэн үг үү?

-Ер нь цусаа өгч байх ёстой. Цусаа байнга тогтмол өгдөг хүн зүрх судасны өвчин болон цус харвалтаас өөрийгөө 80-90 хувь хамгаалдаг гэсэн олон улсын судалгаа гарсан байдаг. Цусыг 350, 400 гэсэн хоёр стандарт хэмжээгээр л авдаг. Таны өгсөн цус гурван төрлийн бүтээгдэхүүн болоод гурван хүнд амьдрал бэлэглэнэ гэсэн үг. Тодруулбал улаан эс, сийвэн, ялтаст эсийн гэсэн гурван төрлийн бүтээгдэхүүнийг бэлтгэдэг. Жил ирэх тутам цус цусан бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдэж байгаа тул та бүхнийг донорын үйлсэд нэгдэхийг уриалж байна.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Бямба гарат бүх нийтээрээ мод тарина

Г.САНЖААХАНД

Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүрийн тав, аравдугаар сарын хоёр дахь долоо хоногийн бямба гарагийг “Мод тарих үндэсний өдөр” болгосон билээ. Энэ өдөр дүүргүүдийн харьяа хэлтэс албад “Шинжлэх ухааны академийн ерөнхий болон Сорилын биологийн хүрээлэнгийн “Ботаникийн цэцэрлэг”-т мод тарих аж. Мөн Засаг даргын Тамгын газрын ажилтан, албан хаагчид мод тарих юм байна. Ингэснээр ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нөхөн сэргээх, агаарын бохирдлыг бууруулах, байгаль орчноо хамгаалах зэрэг өндөр ач холбогдолтой тул дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгж байгууллага, харьяа хэлтэс албадыг идэвхтэй оролцохыг уриалж байгаа юм.

АТҮТ-ийн захирлыг “Шилдэг захирал”-аар өргөмжилжээ

Г.САНЖААХАНД

Төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлж, төрийн өмчийг эзэмших гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлсэн Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын захирал П.Дэлгэрнаранг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас “Шилдэг захирал”-аар өргөмжилжээ. “Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага-2018” өдөрлөгийн үеэр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот төвшин, гэрээний үүргээ сайн биелүүлж ажилласанд талархан “Шилдэг захирал” өргөмжлөлийг гардууллаа. Тус үйлдвэрийн газраас аж ахуй нэгжийн орлогын албан татварт 140 сая төгрөг төлдөг байсан бол өнгөрсөн онд 1.4 тэрбум төгрөгийг улсад төвлөрүүлж, эдийн засгийн үр ашигтай ажилласан байна. Цаашид үйл ажиллагаагаа боловсронгуй болгох, иргэдэд чиглэсэн үйлчилгээнүүдийг шинээр бий болгох зэрэг автотээврийн салбарыг хөгжүүлэхэд тодорхой ажлуудыг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа аж.



Албани улсын Дуррес хотноо сурагчдын дэлхийн аварга шалгаруулах шатрын тэмцээнд “Улаанбаатар Элит” олон улсын дунд сургуулийн сурагч Лхагважатцын Очирбат амжилттай оролцож, дэлхийн аваргын алтан цолыг эх орондоо авчирлаа.

|                                                                                                  |  |                                                                                   |  |                                                                                   |                                                                                                         |                                                                            |  |                                                                                                                                                                                                                                                                  |  |
|--------------------------------------------------------------------------------------------------|--|-----------------------------------------------------------------------------------|--|-----------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------|--|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|
| <div>Улсын бүртгэлийн дугаар: 907300528<br/>Индекс: 100757</div>                                 |  |                                                                                   |  |                                                                                   |                                                                                                         |                                                                            |  |                                                                                                                                                                                                                                                                  |  |
| <div>ЕРӨНХИЙ ЭРХЛЭГЧ:<br/>Б.ОЮУНГЭРЭЛ</div>                                                      |  | <div>ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:<br/><br/>Б.ӨНӨРТОГТОХ<br/>88006842</div>                     |  | <div>УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН АЛБА:<br/>Б.ПҮРЭВЖАВ<br/>99210031</div>               |                                                                                                         | <div>КОМПЬЮТЕР, ГЭРЭЛ ЗУРГИЙН АЛБА:<br/><br/>Б.ГАНЗОРИГ<br/>99998796</div> |  | <div>Редакцийн хаяг:<br/>Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг.<br/>Чөлөөт хэвлэл сан<br/>/Хэвлэлийн хүрээлэн/,<br/>2 давхар. 209, 210, 211 тоот<br/><br/>“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж,<br/>“Чөлөөт хэвлэл сан”-гийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.</div> |  |
| <div></div>   |  | <div>ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:<br/><br/>Н.ПУНЦАГБОЛД<br/>88096454</div> |  | <div>ЭРЭН СУРВАЛЖЛАХ, ШУУРХАЙ МЭДЭЭЛЛИЙН АЛБА:<br/>С.БУДРАГЧАА<br/>90005522</div> |                                                                                                         | <div>САНХҮҮ, МАРКЕТИНГИЙН АЛБА:<br/><br/>М.ДАВААДУЛАМ<br/>99042510</div>   |  |                                                                                                                                                                                                                                                                  |  |
| <div>ФЭЙСБҮҮК: <a href="https://www.facebook.com/MMdardas/">www.facebook.com/MMdardas/</a></div> |  |                                                                                   |  |                                                                                   | <div>ТВИТТЕР: <a href="https://www.twitter.com/MongoliinMedee">www.twitter.com/MongoliinMedee</a></div> |                                                                            |  |                                                                                                                                                                                                                                                                  |  |



АЛДААНД  
ӨГӨХ  
ТАЛАРХАЛ

Үргэлжлэл.  
Түрүүч нь I нүүрт

-Төв талбайн өмнөх цэцэрлэгт хүрээлэнд нүцгэн хэвтэн амарч байсан гадны иргэнийг монголчууд энэ өдрүүдэд нийтээрээ жигшин зэвүүцэв. Гэвч дэлхий нийтэд нүцгэн хэвтэх байтугай, нийтээр амарч унтах зориулалттай цэцэрлэгт хүрээлэн хэдэн зуу бий. Тэр эр цахилгаан ашиглалтын асуудлаар манай улсад зөвлөгөө өгөхөөр ирсэн мэргэжилтэн юм билээ. Төв талбайн өмнөх цэцэрлэгийг нийтээр амарч зугаалж, хэвтэж амарч болдог хүрээлэн гэж андуурснаа тайлбарлаж монголчуудаас уучлалт хүсэв. Үнэн хэрэгтээ биднээс уучлалт гуйх шаардлага байхгүй. Тал шиг уудам газар нутагтаа атлаа дөрвөн уулын дунд чихэгдэж амьдардаг монголчууд үндэсний хэмжээнд нийм цэцэрлэгт хүрээлэн ганцыг ч болов байгуулж чадаагүй тал харуулж өглөө. Үр хүүхдийнхээ тоглож наадах газраас хүмсалдаг хэнбүтэй ч таны энэ үйлдлээс ичсэн биз ээ.

—Бандгар жийптэй, бийлэгжүү хувцасласан нэгэн эр гудамжинд бие засч буй зургийг өдөр шөнөгүй өглөө оройгүй шөйрлэв. Бас гадны жуулчид өнгөрсөн зун хотын захиргааны гадна бие засч бас л шуумжлүүлж билээ. Ухамсар нь доройтсон гэх мэтээр хангалттай санаж зүхсэн доромжилсон. Харин ч сая гаруй хүн амтай мега хотод нийтийн бие засах газар хангалттай байдаггүй гэдгийг үйлдлээрээ харуулсан тэр залууд харин баярлалаа.

Дөрвөн найз ууж хөлчүүрхээд гарахдаа гудамжинд байсан хөшөөг өшиглөөд унагачихаж. Өнөөх нь үйрээд уначихаж. Өнөөгийн залуусын арааргүй хангалттай шүүмжлэв. Тэднийг эрэн сурвалжилж эхэлжээ. Хорин сая төгрөгөөр хийсэн юм чинь хүрлээр цутгасан биз хэмээн эндүүрч явсан хөшөө ямархан чанартай байсныг олон нийт мэдлээ. Төсвийн мөнгийг яаж “цавчдагийг” таниулсан дөрвөн залууд талархъя.

-Төрийн албан хаагчдын өмнөөс нохойтой хамгаалагч тавьж “ичээсэн” Б.Дайчинхүү танд ч уурлалала. Та нохой тавьж төрийн албаныхныг уурлуулагүй бол улстөрчдийн газрын наймааны талаар бид мэдэхгүй өнгөрөх байлаа. Гурван тэрбумаар газраа наймаалцаж, төрийн шийдвэрийг хэрхэн уламдаа гишгэж байдгийг ойлгуулж өгөв. Одоо УИХ-ын гишүүнийхээ нэрийг зарличааарай. Иргэний эр зориг гэдэг юу юунаас чухал юм шүү.

Үүнийг үнэлэх ёстой.


-Олон асуулт асууж амгалан тайван байдлыг нь алдагдуулсанд прокурор эгчээс бас уучлал хүсэхийн ялдамд баярлалаа гэж хэллэ. Хүн хэлэхээс нааш, цаас чичихээс нааш гэгчээр эмх замбараагүй логикийг асуулт асуудаг гэдгээ олон ч сэтгүүлч ойлгоод авчихлаа. Төрийн байгууллагын, тэр дундаа хуулийнхны хүнд суртал, авир араншин, ёс зүй хаана хүрснийг харуулж чадлаа.

-УИХ-ын гишүүн Д.Гантулгадаа баярлалаа. Бид ямархуу залуусаар, ямар зангаргагтай улстөрчдөөр төрөө түшүүлснээ мэдлээ. Бас гэмт хэрэг үйлдэж байхдаа болон нотлох баримт олдсон тохиолдолд гишүүнээс эргүүлэн татах заалтыг УИХ анх удаа чухалчлан авч хэлэлцэж, ажлын хэсэг хүртэл байгууллаа. Гишгэсэн зам мөр бүхнээ хянах ёстойг олон улстөрч, нам дагасан залууст ойгуулж өгөв.

-Уулын модыг унагаж ирлээ хэмээн яамны ажилтанг хөөцөлдсөөр байгаад ажлаас нь халуулж чадсан Хотын Ерөнхий менежер Т.Гантөмөр ч бас баярлах хэрэгтэй. Дарга хүн гэхэд булхайгаа нуух гэжгүйснэй. Бас үнээс хүлээчнэ хэллээ. Суулцагчын үйлдвэрээс худалдан авдаг хэмээн олон жил биднийг хуурсан хотын удирддагуудын булхайг илчлэв. Ойн мод огтлолсон гэдгээ хүлээн зөвшөөрч, ургахгүй бол харунигчаа хүлээхээ ч хэлж байна. Үлгэрт итгэж болохгүй, бодолгүй юм гэдгийг бидэнд мэдрүүлээ.

...Энэ мэтээр үл бүтэх нэгэн хэмээн цоллуулж буй бүхэн бидний тусгал, өнөөгийн нийгмийн тод томруун дүр, ямархуу хотод яаж амьдарч байгааг минь харуулж өгч байгаа учраас энэ бүхэнд зүгээр л талархаад өнгөрье. Магад би тийм алдаа гаргаагүйдээ, маргааш гаргаж болох байснаа засаад өнгөрцгөө.

Б  
А  
Я  
Р  
Л  
А  
Ш  
А  
А



**DARDAS.MN**

ИЛ ТОД, ЭХ СУРВАЛЖТАЙ, БОДИТ МЭДЭЭЛЭЛ

ДЭЛХИЙ ДАМИНД  
Түүний 52 км уршигтай цэвэр  
Бүрүүлж тогтоо

TISSOT  
GRAND VILLA



МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Мансууруулах  
бодис илрүүлэгч  
төхөөрөмж  
ашиглаж эхэллээ

Г.САНЖААХАНД

Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх албаныхан болон зарим аймаг дахь цагдаагийн газарт хар тамхи, мансууруулах бодис болон тэсэрч, дэлбэрэх бодисыг илрүүлэгч, тандан судлагч орчин үеийн тоног төхөөрөмжийг ашиглаж эхэллээ. Эхний ээлжинд ЦЕГ-ын Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтэс, Орхон, Дархан-Уул, Өмнөговь, Сэлэнгэ, Дорнод, Дорноговь аймаг дахь Цагдаагийн газарт АНУ-д үйлдвэрлэгдсэн “Target ID”, “Sabre 5000” тоног төхөөрөмжийг энэ сарын 08-ны өдөр хүлээлгэн өгч, алба хаагчийг дадлагажуулах сургалтыг зохион байгуулсан байна. Энэхүү тоног төхөөрөмж нь хар тамхи, мансууруулах бодис, тэсэрч дэлбэрэх бодисыг нарийвчлан илрүүлэх сүүлийн үеийн дэвшилтэт технологи бөгөөд Англи улсаас ирсэн мэргэжилтнүүд алба хаагчдад дадлагажуулах сургалтыг зохион байгуулж буй нь онцлог юм.

С.Баяр нарыг  
үргэлжлүүлэн  
хорих санал  
гаргажээ

Г.САНЖААХАНД

Ерөнхий сайд С.Баяр, Ч.Сайханбилэг нар өдгөө ШШПГ-ын харьяа цагдан хорих 461 дүгээр ангид саатуулагдаж байгаа билээ. Тэднийг Оюутолгой гэрээ, Дубайн гэрээтэй холбогдуулан өнгөрсөн дөрөвдүгээр сард цагдан хорьсон юм. С.Баяр, Ч.Сайханбилэг нарыг нэг сар цагдан хорих хугацаа өнөөдөр дуусч байгаа юм. Тиймээс тэднийг үргэлжлүүлэн цагдан хорьж шалгах хүсэлтийг өчигдөр прокуророос Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн шүүхэд ирүүлжээ. Үргэлжлүүлэн хорих уу, суллах уу гэдгийг шийдэх шүүх хурал 09:00 цагт тус шүүхэд товлогдсон байна.

Ц.Нямдорж  
сайдаас  
мэдүүлэг авчээ

С.БУДРАГЧАА

Өчигдөр орой ТЕГ-ын Мөрдөн шалгах хэлтэс Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржоос мэдүүлэг авчээ. Баттай эх сурвалжийн өгсөн мэдээллээр нэр бүхий есөн сэтгүүлч, тэдний ар гэрийн 30 гаруй хүний мэдээллийг ЦЕГ-ын мөрдөн шалгах хэлтсийн ажилтнууд хууль бусаар цуглуулсан, тагнаж чагнасан гэх асуудалтай холбогдуулан мэдүүлэг авсан байна.

БАРИМТ & ТАЙЛБАР

“КЁКУШЮЗАН ХӨГЖИЛ САН” ТББ-Д  
НОГДУУЛСАН ТАТВАРЫГ ХУУЛЬ БУСААР  
ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОЖЭЭ



С.БУДРАГЧАА

budragchaas@gmail.com

Японы мэргэжлийн сумод “Мэхний их дэлгүүр” нэрээр алдаршиж, ур чадвар, уран мэхээрээ гайхагдаж байсан Кёкүшюзан Д.Батбаяр 1999 онд “Кёкүшюзан хөгжил сан” ашгийн төлөө бус төрийн бус байгууллагыг эх орондоо байгуулж байжээ.

Байгуулагдсан цагаасаа хойш хүмүүнлэгийн, нийгэмд тустай үйл ажиллагааг явуулж байсан тус ТББ нь Нийслэлийн Засаг даргын тамгын газартай 2001 оны дөрөвдүгээр сарын 24-нд хамтран ажиллах гэрээ байгуулж, залуу гэр бүл, төрийн албан хаагчдын орон сууцаар хангах 1000 айлын орон сууцны цогцолбор босгох төслийг хэрэгжүүлжээ.

Уг гэрээнд “Кёкүшюзан хөгжил сан” ТББ-ыг төлөөлж гүйцэтгэх захирал Б.Батзориг (Одоо УИХ-ын гишүүн, ХХААХҮ-ийн сайдаар ажиллаж буй), Хотын ерөнхий менежер Т.Бадамжунай нар гарын үсгээ зурж байсан.

“Кёкүшюзан хөгжил сан” ТББ дээрх гэрээний хүрээнд 2001-2005 оны хооронд 550 айлын орон сууцыг барьж ашиглалтад оруулсан ба тэдгээр орон сууцаа борлуулж, 2002 онд 1.3 тэрбум, 2003 онд 5.01 тэрбум, 2004 онд 2.5 тэрбум нийт 8.9 тэрбум төгрөгийн орлого олжээ.

Хэдийгээр ТББ нь Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу татвараас бүрэн чөлөөлөгддөг боловч Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасны НӨАТ-ын татвар төлөх ёстой байдаг.


Гэвч “Кёкүшюзан хөгжил сан” ТББ орон сууц борлуулалтаас олсон 8.9 тэрбум төгрөгийн орлогоосоо НӨАТ-ыг төлөөгүй байна. Уг үйлдлийг Үндэсний татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн улсын байцаагч Д.Батбилэг, Х.Алтангэрэл нар шалгаж, 2005 оны есдүгээр сарын 15-ны өдрийн 300591 дугаарт актаар 711.2 сая төгрөгийн татварыг “Кёкүшюзан хөгжил сан” ТББ-д ногдуулсан байна. Тухайн цаг үедээ асар их мөнгө.

“Кёкүшюзан хөгжил сан” ТББ татварын улсын байцаагчдын татварын актыг эс зөвшөөрч анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхэд хандсан боловч ялагдал хүлээжээ. УДШ-ийн 2006 оны зургадугаар сарын

19-ны өдрийн 45 дугаар тогтоолоор “Кёкүшюзан хөгжил сан” ТББ улсад 711.2 сая төгрөгийн НӨАТ төлөх ёстой гэсэн шийдвэр гаргажээ.

Гэвч тус байгууллага УДШ-ийн шийдвэрийг гурван жилийн хугацаанд биелүүлээгүй юм. Шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй гурван жил болсон учраас 2009 оны нэгдүгээр сарын 07-ны өдөр “Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай” 48 тоот шүүгчийн захирамж мөн гарсан байна.

2008 онд “Кёкүшюзан хөгжил сан” ТББ-ын гүйцэтгэх захирал Б.Батзориг Баянзүрх дүүргийн ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдож, улмаар дүүргийн Засаг дарга болж дэвшчээ. Тухайн үед Баянзүрх дүүргийн татварын хэлтсийн даргаар ажиллаж байсан Н.Энхээ Б.Батзоригоос улсад төлөх ёстой 711.2 сая төгрөгийн татвараа төлөхийг шаардахад “Наад асуудлаа орхичих. Би УТЕГ-ын дарга Ц.Оюунбаатартай баз. Таных Нийслэлийн татварын газрын дарга болгож өгье” хэмээн албан тушаал амлаж байсан гэдэг юм.



бүрэн үндэстэй байна. Тус хуульд хамрагдахаар “Кёкүшюзан хөгжил сан” ТББ өмнө нь шүүхэд нэхэмжлэл гаргах үед манай байгууллагын ажилтнууд өршөөлийн хуульд хамруулахгүй байх талаар харну тайлбар гаргаж байсныг үүгээр залруулж байна” гэх тайлбарыг гаргаж байжээ.

Үндэсний татварын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Оюунбаатарын дээрх тайлбарт үндэслэн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч А.Отгонцэцэг “Кёкүшюзан хөгжил сан” ТББ-д татварын улсын байцаагчийн 300591 дугаарт актаар тогтоосон 711.2 сая төгрөгийн торгуулийн Татварын өршөөлийн хуульд хамруулан, зохих журмын дагуу чөлөөлсүгэй гэх 223 дугаарт захирамжийг гаргасан байна.

Татварын өршөөл үзүүлэх тухай 2008 оны хуулийн хэрэгжих хугацаа 2008 оны наймдугаар сарын 01-ний өдрөөр хэрэгжих хугацаа нь дуусгавар болсон байхад Захиргааны хэргийн шүүх хүчингүй болсон хуулийг хэрэглэсэн ноцтой зөрчил гаргасан байдаг юм.

УДШ-ийн 2007 оны арваннэгдүгээр сарын 15-ны өдрийн “Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах тухай” зөвлөмжид “Хяналтын шатны шүүх хэргийг хянан хэлэлцэж, тогтоол гаргасан бол хүсэлтийг Улсын Дээд шүүхэд гаргана” хэмээн заасан байдаг аж. Өөрөөр хэлбэл “Кёкүшюзан хөгжил сан” ТББ-д татварын торгууль ногдуулсан асуудлыг УДШ-ээр хэлэлцээд эцэслэсэн учраас, торгуулийг хэргийг хэрэгсэхгүй болгох асуудлыг Дээд шүүхээр хэлэлцүүлэх ёстой байсан аж. Гэтэл Дээд шүүхээр бус захиргааны хэргийн анхан шатны шүүхээр тус асуудлыг шийдвэрлэж хэрэгсэхгүй болгосон нь хуулийг ноцтойгоор зөрчсөн үйлдэл байж болзошгүй юм.

СОНИН ЗАХИАЛАХАД  
ХЯЛБАР БОЛОО

УТАС: 9919-7866



ХӨНДӨХ СЭДЭВ

## ЦЭЦИЙН ГУРВАН ГИШҮҮН Д.СУГАРТАЙ ХАМТ “СУГАРНА”

Б.ПҮРЭВЖАВ

Үндсэн хуулийн цэц бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж чадахгүйд хүрэх нь. Цэц нийт есөн гишүүнтэй үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд Д.Сугар, Н.Жанцан, Д.Наранчимэг, Т.Лхагва нарын бүрэн эрхийн хугацаа дуусч, үүнтэй зэрэгцэн дараагийн томилгоо яригдаж эхэллээ. Цэцийн есөн гишүүний гурвыг УИХ, гурвыг нь Ерөнхийлөгч, гурвыг Улсын Дээд шүүхийн санал болгосноор УИХ зургаан жилийн хугацаагаар томилох эрхтэй байдаг. Хамгийн хачирхалтай нь Д.Наранчимэг, Н.Жанцан нарын

бүрэн эрхийн хугацаа өнгөрсөн жилээр дуусгавар болсон байх юм. Тэгвэл Т.Лхагва, Д.Сугар нарын бүрэн эрхийн хугацаа өчигдөр дууслаа. Тэгэхээр Цэцийн дөрвөн гишүүний бүрэн эрхийн хугацаа дууссан гэсэн үг. Өмнө нь Т.Лхагва, Д.Наранчимэг, Н.Жанцан нарыг Ерөнхийлөгч нэр дэвшүүлж байсан бол гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан дараагийн томилгоог оруулж ирэх үлдлээ. Д.Наранчимэгийн оронд УИХ-ын гишүүн асан Р.Бурмааг Ерөнхийлөгч Х.Баттулгын зүгээс өнгөрөгч оны аравдугаар саналд болгосон ч Хууль зүйн

байнгын хорооны хуралдаанаар хэлэлцээд, дэмжихгүй гэх шийдвэрийг гаргаж байсан удаатай. Харин энэ удаа УИХ-ын гишүүн асан Р.Бурмааг дахин оруулж ирж магадгүй гэсэн таамаг хүртэл байна.

Үндсэн хуулийн цэцийн гишүүдээс хамгийн их хэл ам таталж, элдэв хар бараан зүйлд нэр нь холбогдож явдаг хүн бол Д.Сугар. Түүнийг УИХ-аас нэрийг дэвшүүлж, одоогоос зургаан жилийн өмнө томилж байсан юм. Түүнийг ТӨХ-ны даргаар ажиллаж байх үедээ өмч хувьчлалыг гувчуулж их хэмжээний ашиг олсон, “МИАТ” ХК-ийн захирал асан Д.Эрдэнэбилэгтэй

үгсэж “Дайны эрсдэлийн даатгал” гэх зүйлийг бий болгон их хэмжээний хөрөнгө завшсан хэмээн хэвлэлээр шуугиж байсан ч Цэц түүнийг хамгаалсаар өнөөдрийг хүрсэн юм. Мөн Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийг Өмнөд Африкийн “Стандарт” банкинд барьцаалахад оролцсон, Японы Токио хотын Адачи дүүргийн Шиндэн хороололд 535 сая төгрөгөөр, БНСУ-ын Чэжүд 600 сая воноор худалдаж авсан байраа ямар эх үүсвэрээр авсан зэргийг шалгах, тогтоох олон асуудлууд байсан хэдий ч Цэцийн гишүүн гэх үндэслэлээр шалгуулахгүй явсаар өнөөдрийг

хүрсэн юм.

Одоо түүнийг шалгахад хуулийн талаас ямар ч саад тээг байхгүй боллоо. Түүнтэй холбоотой олон хэргүүдийг эрх бүхий байгууллага нь шалгаж гэм зэм байгаа бол ял шийтгэлийг нь оноох гүтгэсэн бол цагаатгах нөхцөл бүрдэв. Өөрөөр хэлбэл, түүнийг тойрсон оньсого мэт элдэв зүйлийн зангилаа тайлагдах нь ээ. Д.Сугарт одоо орогнох, нуутдах газар үлдсэнгүй. Тэр хаах халхавч бас бамбайгүй боллоо. Тиймээс өөрөө хэлсэн шигээ хууль хяналтын байгууллагын өмнө шалгуулахаар гүйгээд очих биз ээ.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## С.Бямбацогт: Ядуурлын улмаас хүмүүс гэмт хэрэг үйлдэж байна

Б.ПҮРЭВЖАВ

УИХ-ын гишүүн С.Бямбацогт, Л.Мөнхбаатар, Ш.Раднаасэд, Ж.Батзандан нарын гишүүдийн санаачлан боловсруулсан Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг өчигдөр Төрийн ордонд боллоо. Хэлэлцүүлэгт холбогдох байгууллагын удирдлага, албан тушаалтнууд оролцож санал бодлоо илэрхийлсэн юм. Тус хуулийн төсөлд гэмт хэрэг зөрчлийг тогтоох, арилгах, шинээр бий болохоос урьдчилан сэргийлэх тухай нарийвчлан тусгасан байна. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа ГХУСТХ зөвхөн нүдэнд ил харагдаж буй ахуйн хүрээний гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудлыг тусгажээ. Тэгвэл дээрх боловсруулсан хуулийн төсөлд ил болон далд үйлдэгддэг бүхий л гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан байна. Мөн хууль сахиулагчдад зөвхөн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцгэж үүрэг өгөх биш тэднийг бэлтгэдэг, сургадаг, техник тоног төхөөрөмж, ажиллах баталгааг нь хангадаг, эрх зүй, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэдэг байхаар хуулийн зохицуулалт хийсэн аж. Урьдчилан сэргийлэх ажилд монголын төр, төрийн бүхий л байгууллага, албан хаагчид, иргэд, олон нийтийн оролцоог хангах, иргэдийн саналыг авах, санаачилгыг дэмжих, тэдний хяналтыг тогтоох замаар хуулийг хэрэгжүүлэх ёстой гэж үзсэн байна. Тус хуулийг санаачилсан УИХ-ын гишүүн С.Бямбацогт “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийг 1997 онд баталсанаас хойш 20 гаруй жил өнгөрч байна. Тус хуульд хүний нүдэнд ил үйлдэгддэг буюу гудамж талбайд үймээн самуун гаргах, танхай, хулгай, дээрэм гэх мэт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх, хэрхэн тэмцэх талаар тусгаж зохицуулсан байсан. Өнгөрсөн хугацаанд тодорхой бодлогын, томоохон зохицуулалтууд буюу гэмт хэрэг үйлдэгдэх, гэмт хэргийн золиос болох нөхцөл шаардлага, шалтгааныг хэрхэн арилгах талаар зохицуулалтгүй явсаар ирлээ. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын эдийн засгийн өсөлт муу, ард иргэдийн амьдрал ядуу байна гэдэг бол гэмт хэрэг үйлдэгдэх, түүнд өртөх, золиос болох нэг шалтгаан болж буй. Учир нь ажилгүйдэл, ядуурлын улмаас хүмүүс амьдрахын эрхэнд гэмт хэрэг үйлдэх, зөрчил гаргах, бусдыг хохироох нөхцөл байдал бий болоод байна. Тиймээс гэмт хэрэгтэй зөвхөн хуулийн байгууллага тэмцэх бус Үндсэн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж монголын төр анхаарах ёстой гэж үзэн хуулийн төслийг боловсрууллаа” гэсэн тайлбарыг өгсөн юм.

## Ерөнхийлөгчийн саналыг дэмжсэнгүй

Б.ПҮРЭВЖАВ

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны өчигдрийн хуралдаанаар 2018 оны тавдугаар сарын 03-ны өдрийн Е/08 тоот албан бичгээр Ерөнхийлөгчөөс УИХ-д ирүүлсэн саналыг хэлэлцлээ. Хэлэлцэх асуудалтай холбогдуулан УИХ-ын гишүүд уг хэлсэн юм. Тухайлбал, УИХ-ын гишүүн Л.Мөнхбаатар “Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг томилох Ерөнхийлөгчийн санал нь хууль зөрчсөн гэж үзэж байна. Авлигын эсрэг хуульд Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг чөлөөлөх, огцруулахтай холбоотой тодорхой зохицуулалт бий. Эдгээр албан тушаалтнууд нь гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхээр тогтоогдвол албан тушаалаас огцруулах зохицуулалттай” гэв. Хуралдааны төгсгөлд УИХ-ын гишүүн Б.Дэлгэрсайхан Авилгатай тэмцэх газрын дарга, дэд даргыг томилж Ерөнхийлөгчийн саналыг хууль зүйн хувьд УИХ авч хэлэлцэх үндэслэлгүй хэмээн тайлбарлаад хууль зөрчсөн, агуулгын зөрчилтэй уг саналыг хэлэлцэхгүй байх горимын санал гаргасан юм. Үүнийг хуралдаанд оролцсон 15 гишүүний 80 хувь нь дэмжив.



Б.ПҮРЭВЖАВ

*Сангийн сайд Ч.Хүрэлбаатартай Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2019 оны Үндсэн чиглэлийн талаар тодрууллаа.*

**-2019 оны Үндсэн чиглэл өмнөхөөсөө юугаараа ялгаатай вэ. Мөрөөдлийн жагсаалтыг Үндсэн чиглэлд тусгадаг гэсэн шүүмжлэл их байдаг. Та үүнтэй санал нийлэх үү?**  
-2013 оноос хойш уруудсан эдийн засгийн уналтыг зогсоолоо. Ийм үйл явц 2017, 2018 онуудад үргэлжлээд явж байна. 2019 онд бид эдийн засгийн өсөлтийг бий болгох замаар ард иргэдийн амьжиргааны төвшинг сайжруулна. Монголчуудынхаа орлогыг нэмэгдүүлэх зарчмыг барьж Үндсэн чиглэлийг оруулж ирлээ. Өөрөөр хэлбэл, 2013 оноос хойш унасан эдийн засгийн хямралыг 2018 оноор цэг тавиад урагшаа явж байна. Өрийн дарамтыг гэтлээд гарч байгаа юм. Ингэхээр 2019 онд Монгол Улсад өсөлтийг хангах, ард иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, бизнес эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилго тавин ажиллаж байна.

**-Энэхүү зорилтыг хангаж ажил-**

**лахын тулд ямар бодлого хэрэгжүүлэх юм бэ?**

-Хамгийн гол чирж, хөдөлгөж явах гол хүчин зүйлс нь хувийн хэвшил гэж харж байгаа. Учир нь Монгол Улсад ажил хөдөлмөр эрхлэх боломжтой 1.4 сая хүн бий. Үүнээс төрийн алба 188 мянган хүнийг ажлын байраар хангадаг. Харин үлдсэн хэсгийг нь хувийн хэвшлийнхэн ажлын байраар хангаж байна. Цаашдаа хувийн хэвшлийг дэмжинэ. Дэмжихийн тулд өсч байгаа эзэлийн хүүг буулгах юм. Мөн эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг сайжруулах, хямралыг давах арга хэмжээний үр дүнд эзэлийн хүү бууна. Одоогоор зарим арилжааны банкууд сарын 0.2 буюу жилийн 2.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мөнгөний нийлүүлэлт нэмэгдэж байгаа. Монгол Улсын эзэлжих зэрэглэл нэмэгдэж эхэллээ. Экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр гэрээ хэлцэл амжилттай явагдаж байна. Тэгэхээр 2019 оныг Монгол Улсын хөгжлийг тэтгэх гол жил байх болов уу гэж харж байгаа. ОУБС-тай хамтраад хэрэгжүүлж байгаа хөнгөлттэй зээлүүдийг бодитой зөв, үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлийн ажлууд явагдаж байна. Мянганы сорилтын сан, Төв цэвэрлэх байгууламж, хил

ӨДРИЙН ТОДРУУЛГА

## Ч.ХҮРЭЛБААТАР: 2019 ОНД ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ХАНГАНА

боомтуудыг цэгцлэх ажил болон жижиг дунд үйлдвэрийн зээл зэрэг олон асуудал давхар орж ирж байгаа. Уул уурхайгаас гадна бусад салбарыг дэмжихийн тулд татварын багц хуулийг удахгүй УИХ-д өргөн барина. Татвар төлөгчдийн бааз суурийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдэх юм.

**-Гурван тулгуурт хөгжлийн бодлогыг Засгийн газраас танилцуулсан. Үндсэн чиглэл энэ бодлоготой хэрхэн уялдах вэ?**

-Гурван тулгуурт хөгжлийн бодлого нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй, Монгол Улсын хэмжээнд хэрэгжүүлдэг томоохон хөтөлбөртэй уялдуулсан бодлого юм. Гурван тулгуурт хөгжлийн бодлого гэдэг бодлогуудыг уялдуулж өгч байна гэсэн үг. Үндсэн чиглэлтэй нягт уялдаж байгаа.

**-Дунд хугацаанд төсвийн тэнцлийг эерэг болгох зорилтыг хэрхэн тусгасан бэ?**

-2019 оноос эхлээд төсвийн тэнцлийг эерэг болгочихож болохгүй байгаа юм. Учир нь 2013 оноос эдийн засаг хумигдаад агшчихсан. Дахиад төсвийн тэнцлээ нэмэх болгоно гээд явчихвал эдийн засгаа хумих гээд байна. Тэгэхээр эдийн засгаа тэлэх зорилгоор 2019 онд төсвийг алдагдалтай оруулж ирж байгаа. Гэхдээ төсвийн алдагдлыг өндөр хүүтэй зээлээр санхүүжүүлэхгүй байхаар бодож хийсэн. Гадны хүү багатай хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөр болон тусламжийг ашиглана. Ингэж үзэж төсвийн алдагдлыг тооцсон. Хасах 2.1 их наядын алдагдал эдийн засагт сөрөг үр дагавар авчрахгүй. Арилжааны банкуудаас зээл авахгүй. Арилжааны банкнаас зээл авахаар хувийн хэвшлийг түлхэж гаргадаг. Тэгвэл ийм зүйл болохгүй.

**-Төсвийн алдагдлыг бууруулахад өөр ямар арга хэмжээ авч байгаа бол?**

-Төсвийн алдагдлыг бууруулах бодлого барьж байгаа. Алдагдлыг шууд тэглэсэн бодлого баримталж болохгүй. Төсвийн алдагдлыг бууруулах талаар тооцоолж байна. Гэхдээ өнгөрсөн дөрвөн жилийн турш агшсан эдийн засгийг тэлэх шаардлагатай. Өнгөрсөн жилээс аж ахуйн нэгжүүд идэвхжиж, үйл ажиллагаа нь сэргэх хандлагатай байна. Хөнгөлөлттэй зээлээр санхүүжих хэмжээгээр төсвийн алдагдал буурч, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэхгүй гэж тооцсон. Орлогыг шахаж, тооцож оруулж байгаа. Зэс, нүүрс, алтны үнийг өндөр тооцож оруулсан.

## НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЗАР

“Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар”-ын 2018 оны 04 дүгээр сарын 17-ны 128 тоот тогтоолоор дараах 2 автомашиныг нээлттэй дуудлага худалдаагаар худалдахаар шийдвэрлэв.

### 1. Дуудлагаар худалдах хөрөнгийн танилцуулга

| № | Автомашины марк                     | Улсын дутаар | Үйлдвэрлэсэн он/Ашиглалтанд орсон он | Худалдах доод үнэ | Дэнчингийн хэмжээ | Дэнчин байршуулах данс      | Хаяг                                                                                                | Холбоо барих утасны дутаар | Салбар      |
|---|-------------------------------------|--------------|--------------------------------------|-------------------|-------------------|-----------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------|----------------------------|-------------|
| 2 | УАЗ фургон                          | 57-23 ГСА    | 2007/2007                            | 1.500.000         | 375.000           | 300000256304 /Төрийн банк/  | Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3-р баг “Петротрак” ХХК-ний байр, Говьсүмбэр аймгийн автотээврийн төв | 99084798, 88280648         | Говь-сүмбэр |
| 5 | Мицубиши пажеро (Mitsubishi Pajero) | 00-95 ДГО    | 2001/2003                            | 1.500.000         | 375.000           | 280000259460 /Төрийн базнк/ | Дорноговь аймаг, Сайншанд сум, 3-р баг, Дорноговь аймгийн автотээврийн төв                          | 70522367, 89770259         | Дорноговь   |

### 2. Дуудлага худалдааны ерөнхий мэдээлэл

Дуудлага худалдаа 2018 оны 06 сарын 11-ний өдрийн 11:00 цагт тухайн салбарын автотээврийн төвийн байранд болно.

### 3. Дуудлага худалдаанд хүсэлт ирүүлэх

Дуудлага худалдаанд оролцох хүсэлтийг 2018 оны зургадугаар сарын 11-ний 10.50 цаг хүртэл тухайн салбарын автотээврийн төвийн байранд хүлээн авна. Хугацаа хоцорсон хүсэлтийг

хүлээн авах боломжгүйг анхаарна уу.

Бүртгүүлэхээр ирэхдээ дэнчингийн мөнгийг тухайн салбарын дансанд тушаасан баримт, иргэний үнэмлэхийн хамт авчирна уу.

### 4. Худалдах хөрөнгийн талаар мэдээлэл авах

Дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийг үзэж болох бөгөөд холбогдох мэдээллийг утсаар авна уу.



ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА



Мэргэжлийн хяналтын байцаагч нар дөрвөн чиглэлд хуваагдан ажилласан. Гэхдээ уг ажил иргэдийн эсэргүүцэлтэй тулгарсан ч шаардлагын үр дүнд явуулын худалдаа эрхлэгчид нийтийн эзэмшлийн талбайг чөлөөлсөн юм.



# С.ДАВААСҮРЭН: ТӨР АЖЛАА ХИЙЖ БАЙНА Н.ЭНХТУЯА: ТӨРӨӨС НЭГ УУТ ГУРИЛЫН МӨНГӨ ГУЙГААГҮЙ

Төгсгөл.  
Түрүүч нь I нүүрт

Тус ажиллагаанд НМХГ, Сүхбаатар дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтэс, Сүхбаатар дүүргийн цагдаагийн хоёрдугаар хэлтэс, дүүргийн газрын алба, онцгой байдлын алба, замын цагдаагийн албан хаагчид хамтран ажиллах юм байна.

НМХГ-ын дэд дарга С.Даваасүрэн “Тазар чөлөөлүүлэх мэдэгдлийг ААН, иргэдэд удаа дараа өгсөн. Сүүлийн хоёр гурван сар хэвлэл мэдээллийн байгууллагуудаар мэдээлж байгаа. Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөнд заасны дагуу энэ хэсэгт Долдугаар хороолол босно. Энэ хүрээнд 100 айлын газрыг цэгцлэх үүргийг хотын удирдлагаас өгсөн. Цаашлаад засмал замыг өргөсгөх асуудал яригдаж байгаа. Нөгөөтэйгүүр энд байнга оршин суудаг иргэдээс гомдол их ирдэг. Авто замын түгжрэлээс гадна, орчны дуу чимээ, тоосжилт их байгаагаас амьдрах орчин маш их хүндрэлтэй байгаа талаар гомдол ирүүлж байна. Тиймээс төр ажлаа хийж байна. Эдгээр иргэн, аж ахуйн нэгжийг аль нэг тийшээ нүүлгэх, байршуулах арга хэмжээг авахгүй. Хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа болон хууль бус үйл ажиллагаа явуулж буй иргэдийг цэгцлэх арга хэмжээг авч байна. Нэг зохион байгуулалтад орж, нэг зорилготой ажиллана. Дүүрэг нийслэлийн прокуроруудад хандсан. Хуулийн дагуу арга хэмжээг авч ажиллана” гэсэн юм.

Уг ажлыг ахлан гүйцэтгэж буй Сүхбаатар дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга М.Баасандоржоос нийтийн эзэмшлийн зам талбай чөлөөлүүлэх ажлын талаар цөөн асуултад хариулт авлаа.

**-Худалдаа эрхлэгчдэд газар чөлөөлөх мэдэгдлийг хэзээ өгсөн бэ, Газраа сайн дураар чөлөөлөхгүй байгаа иргэн, байгууллагад ямар арга хэмжээ авч байна?**

Нийтийн эзэмшлийн зам талбайд дур мэдэн ТҮЦ, павильон байрлуулж, худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа нөхдүүдийг журамлана. Мөн нийтийн эзэмшлийн зам талбай дээр авто машинаа байрлуулж, түгжрэл үүсгэж байгаа асуудлыг хуулийн хүрээнд шийднэ. Нийтийн эзэмшлийн зам талбай дээр хууль бусаар үйлчилгээ явуулж байгаа иргэдэд талбайг чөлөөлж, хууль мөрдөж ажиллахыг анхааруулан найм хоногийн өмнөөс 376 байгууллага, хувь хүнд мэдэгдэх хуудас өгсөн. Мэдэгдлийн хугацаа албан ёсоор /өчигдөр/ 10.00 цагт дууссан. Энэ хугацаанд сайн дураараа ТҮЦ-ээ нүүлгэсэн нэг иргэн байгаа. 70 гаруй худалдаа эрхлэгчид мэдэгдлийг хүлээн зөвшөөрч сайн дураараа нүүгээд байна. Хууль ёсны шаардлага биелүүлэхгүй иргэдэд эрх хязгаарлах арга хэмжээг хуулийн хүрээнд авах ажил одоо явагдаж байна. Тус ажиллагаанд хууль хүчний байгууллага хамтран оролцож байгаа.

**-Цаашид ямар арга хэмжээ авах вэ?**

Өнөөдөр, маргаашдаа нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлнө. Дараагийн үе шат нь зөвшөөрөлгүй үйлдвэрлэл явуулж байгаа хүмүүстэй тулж ажиллана. Нийтдээ 70 орчим барилгын модон эдлэл, тавилгын үйлдвэрлэл явуулдаг байгууллага, иргэн байна. Мөн 52 чулуу төмрийн үйлдвэрлэл байгаа. Үйлдвэрийн газруудад нэг сарын хугацаа өгсөн. Энэ хугацаанд хуулийн шаардлага биелүүлэхгүй бол албадлагын арга хэмжээг авна.

**-Сайн дураараа үйлдвэрээ хааж, газар чөлөөлөлтөд хамрагдаж байгаа иргэдэд нийслэлээс шинээр байрших газар олгосон уу?**

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдий хурлаас барилгын материалын үйлдвэрлэлийг Налайх дүүрэг рүү төвлөрүүлэх бодлого барьж байгаа.

...Хууль бусаар үйлчилгээ эрхэлж буй иргэд, ААНБ-аас мэргэжлийн хяналтын байцаагчийн тавьсан шаардлагыг хэрхэн хүлээн авч байгаа талаар тодрууллаа.

н.Сэлэнгэ: Ийм хүмүүс хаана очих юм

/Жижиглэн худалдаа эрхлэгч/

-Та нар төрийн сүрийг үзүүлж ядарсан ард иргэддээ дээрэлхэж байна. Бидний дунд нэг хужаа байсан бол та нар хамраа ч зүглүүлэхгүй. Энд худалдаа наймаа эрхэлж байгаа хүмүүс өрх толгойлсон, тэтгэврийн хэдэн хөгшин, тахир дутуу хүмүүс л байдаг. Ийм улсууд хаана очих юм. Бүх л газар эзэнтэй болсон. Та нар биднийг хөөгөөд явуулсны дараа өөр нэг мөнгөтэй хүн ирээд л эзэн суучихна. Хавар та нар хоёрхон ТҮЦ байхад аваад л явсан. Одоо энэ буудал дээр хэдэн ТҮЦ байгааг хар.

...Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөнд заасны дагуу энэ хэсэгт Долдугаар хороолол босно. Энэ хүрээнд 100 айлын газрыг цэгцлэх үүргийг хотын удирдлагаас өгсөн. Цаашлаад засмал замыг өргөсгөх асуудал яригдаж байгаа. Нөгөөтэйгүүр энд байнга оршин суудаг иргэдээс гомдол их ирдэг. Авто замын түгжрэлээс гадна, орчны дуу чимээ, тоосжилт их байгаагаас амьдрах орчин маш их хүндрэлтэй байгаа талаар гомдол ирүүлж байна. Тиймээс төр ажлаа хийж байна...

Н.Энхтуяа: Би энд ганцаараа зогсоогүй

/Жижиглэн худалдаа эрхлэгч/

-Сүүлийн гурван жил газар эзэмших зөвшөөрөл авалгүй худалдаа наймаа эрхэлсэн нь үнэн. Ерөөсөө зөвшөөрөл олгохоо больчихсон шүү дээ. Би энд ганцаараа зогсоогүй. Арав гаруй жил худалдаа наймаа эрхэлж амьдралаа залгуулж байна. Энд зогсч наймаа эрхэлдэг хүмүүс бүгд банкны зээлтэй. Дээр нь хувь хүнээс хүүтэй мөнгө зээлсэн байдаг. Өдрийн 25000 төгрөгийн зээлийг нэг хүн төлдөг. Төрөөс нэг уут гурилын мөнгө ч гуйгаагүй. Татвараа төлчихдөг” хэмээж байв.

...Дээрх хурцадмал нөхцөл байдлыг хэрхэн шийдвэрлэх талаар НМХГ-ын Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч Ж.Быхараас тодруулахад “Энэ бол нийтийн эзэмшлийн зам талбай. Бид хяналт шалгалт хийгээд шаардлага тавихаар ил задгай худалдаа эрхэлдэг хүмүүс бид яаж амьдрах юм гэдэг. Энэ хүмүүс хүнс зардаггүй гэж хэлдэг. Худалдаачдыг дагаад чанасан өндөг, чихэр ундаа ус гараад ирдэг. Нэг хүн амьдралаа авч яваа нь энэ гээд гарал үүсэл нь тодорхойгүй хадгалалтын горим зөрчигдсөн хүнсний бүтээгдэхүүн зарж, ард иргэдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж, нийтийн эзэмшлийн зам талбайд худалдаа хийгээд байж болохгүй. Бид хуулийн дагуу тавих шаардлагаа тавиад өөрсдөө нүүчих гэж шаардаж байгаа. Олон хоногийн өмнөөс мэдэгдэл өгсөн учир сайн дураараа газраа чөлөөлөөгүй тохиолдолд албадан нүүлгэх арга хэмжээ авна” гэв.

Зарим хүмүүс энэ мэт үл ойлголцол үүсгэж байхад хуулиа дээдэлж, үүргээ ухамсарласан иргэдийн талаар НМХГ-ын Хөдөлмөрийн эрүүл ахуйн улсын байцаагч Ч.Бүжинлхам “Дээврийн төмөр, вакум цонх, модон эдлэл, тавилга, чулуун бүтээцийн үйлдвэрлэл эрхэлж буй иргэдийн газрын зөвшөөрөл гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгогдсон байдаг. Өнөөдрийн байдлаар үйлдвэрлэл эрхэлж байгаа 70 үйлдвэрийн 32 нь нүүлгэн шилжүүлэх мэдэгдлийн дагуу үйл ажиллагаагаа зогсоосон байна. Эдгээр үйлдвэрийн эзэд бидэнд үйлдвэрлэл эрхлэх газар зааж өгвөл тэнд очиж үйлдвэрлэлээ явуулна гэж байна” хэмээсэн юм.

Нийтийн эзэмшлийн зам талбайг албадан чөлөөлүүлж байгааг харж зогссон иргэн О.Болдбаатар “Цөөн хэдхэн хүний эрх ашгаас болж энд амьдардаг иргэдийн эрх ашиг ноцтойгоор зөрчигддөг. Өнөөдөр өглөө хүүхдээ цэцэрлэгт хүргэж өгөх гээд явж байхад нэг л чөлөөтэй оргиод явчихсан юм. Нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлүүлж байгаа нь үнэхээр зөв ажил” хэмээн талархаж байлаа.

## ЦАХИМ ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо: 2018 оны тавдугаар сарын 10**  
**Тендер шалгаруулалтын нэр:**  
*Хөдөлмөр хамгаалах хэрэгсэл, ажлын хувцас*  
**Тендер шалгаруулалтын дугаар:**  
АТУТ/201801019

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ нь эрх бүхий тендерт оролцогчдоос “Хөдөлмөр хамгаалах хэрэгсэл, ажлын хувцас” тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Багц 1 Дүрэмт хувцас, өвөл зуны аж-

лын хувцас;

Багц 2 Ажлын гутал;

Багц 3 Хамгаалах хэрэгсэл

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлийг 50,000 төгрөгөөр худалдан авна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна. Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

**Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 оны аль нэг жилд борлуулалтын хэмжээ 100,0 сая төгрөгөөс доошгүй байх;  
**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас доошгүй байх;

**Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:**

Сүүлийн 2 жилийн баталгаажуулсан санхүүгийн тайланг аудитын зөвлөмжийн хамтаар ирүүлэх.

Тендерт оролцогч санал болгож буй тендерийн үнийн дүнгийн 2 хувиар тооцож тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2018 оны зургадугаар сарын 11-ний өдрийн 15.00 цагаас өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хуудаст цахим хэлбэрээр ирүүлэх бөгөөд нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2018 оны зургадугаар сарын 11-ний өдрийн 15.30 цагт нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй

Дотоодны давуу эрх Багц 1,2 тооцно,

Багц 3 тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**УБ хот, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, Тээвэрчидийн гудамж, өөрийн байр, Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн Г.Чинзориг, Утас: 99101763**



АУГАА ЭХ ОРНЫ ДАЙНЫ ЯЛАЛТ-73 ЖИЛ



# ЯЛАЛТЫН БИДНИЙ Ч БАЯР

–Амиа алдсан хүн бүхэн бидний зүрх сэтгэлд мөнх орших болно–

Төгсгөл.  
Түрүүч нь I нүүрт

Түүнчлэн, өнгөрсөн гуравдугаар сард болсон Ерөнхийлөгчийн сонгуульд үнэмлэхүй ялалт байгуулж, дөрөв дэх удаагаа төрийн тэргүүнээр сонгогдсон В.Путин дэлхийн хоёрдугаар дайнд амь үрэгдсэн нэр нь үл мэдэгдэх цэргийн булш дурсгалын цогцолборт цэцэг өргөснийхөө дараа нийт ард түмэндээ хандан үг хэлсэн юм. Тэрбээр “ЗХУ-ын баатрууд дайнд ялалт байгуулахын тулд эцсийн сумаа дуустал байлдсан. Тэдний эр зоригийг хэзээ ч мартах учиргүй. Амиа алдсан хүн бүхэн бидний зүрх сэтгэлд мөнх орших болно. Эх орныхоо төлөө амиа өргөсөн баатруудаа бид мартахгүй. Дайны хар өдрүүдэд олон хүн хайртай эцэг, эх, нөхөр, эхнэр, анд нөхдөө алдсан. Тэрхүү аймшигтай өдрүүдийг бид мартах учиргүй. Өнөөдөр бидэнтэй хамт байхгүй байгаа ахмад дайчдынхаа өмнө мэхийн ёсолж байна. Дайны уршгаар олон мянган хүн амиа алдаж, гэр бүлээсээ хагацсан. Энэ дайн бол амьдралын эсрэг дайн байсан.

Дэлхийн энхтайвныг бид амархан олоогүй. Тиймээс олон улс нэг нэгэнтэйгээ эвтэй байх учиртай. ОХУ бүх улстай эрх тэгш харьцаатай байдаг. Бидний эрх тэгш байдал мөнхөд үргэлжлэх болно. Дайнд үрэгдсэн хүмүүст бид хүндлэл үзүүлэх ёстой. Энэ бол залуу үеийнхэнд үлгэр жишээ болсон үйл явдал гэдгийг мартах учиргүй. Хүн бүхэн тэдний хийсэн эр зоригийг магтан шагших ёстой. Ахмад дайчдынхаа захиасыг бид үргэлж санаж бас биелүүлэх болно. Агуу их Ялагтын баярын мэнд хүргэе” хэмээлээ. Манай улс ч цус урсгасан хүйтэн дайны хор уршгийг чамгүй амссан юм. Агт мориноос эхлээд эдийн засгийн хэмжээтэйгээ харьцуулахад үлэмж хэмжээний эд материалын тусламж үзүүлж байжээ. Мөн Халимаг, Тува, Буриад гэх мэт Монгол туургатнууд Улаан армийн эгнээнд тулалдаж байсан гэдэг.

Ялалтын баяр, бидний ч баяр юм. Ялалтын баярын 73 жилийн ойн түүхт өдрийг Монголын ард түмэн ч хүйтэн дайныг дурсан санаж, баатарлагаар амь үрэгдсэн дайчдын гэгээн дурсгалыг хүндэтгэлээ. Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга Д.Даваа болон албаныхан, ОХУ-ын Элчин сайдын яамныхан, манай улсад ажиллаж амьдарч буй ОХУ-ын иргэд Зайсан толгой дахь Зөвлөлтийн дайчдын болон Г.К.Жуковын хөшөөнд цэцэг өргөж хүндэтгэл үзүүлэв.


Мөн Монгол цэргийн музейд Монгол Улсын баатар Дашийн Данзанваанчигийн дурсгалд зориулсан номын нээлт болсон бол Офицеруудын ордонд “Түүхэн гавьяаны эзэд, найрамдлын дуулал” баярын концерт зохион байгуулагдлаа.



Шинээр танилцуулсан зэвсэг, техникүүд

Тавдугаар үеийн Су-57

СУ-57 нь хамгийн сүүлийн үеийн сайжруулсан загвартай, агаараас газар руу, газраас агаар руу пуужин харвана. Мөн зургаан ширхэг дуунаас хурдан BrahMos-A пуужинг зөөвөрлөх хүчин чадалтай аж.



“Кинжал” пуужин

Тус пуучин нь дайсны ямар ч агаарын хамгаалалтыг нэвтрэх өндөр хүчин чадалтай. МиГ-31 сөнөөгч онгоцонд тээвэрлэгдэн 2000 км хүртэл зайд байндаа тусдаг, цагт 10000 км хурдаар нисэх чадалтай гэнэ.

“Терминатор”

Уралийн вагон үйлдвэрийн шинэ бүтээл “Терминатор” тодогдолтой танк дэмжигч байлдааны машин нь мөн энэ жил анх удаа олны өмнө дэлгэгдлээ. “Атака” нэртэй дөрвөн ширхэг танк эсэргүүцэгч пуужинтай, 30 мм-ийн хоёр их буу, хоёр гранат харвагчтай, мөн бууны ам нь 7.62 мм голч бүхий пулемёт зэргээр тоноглогджээ.



Жолооч, нисгэгчгүй робот зэвсгүүд

Энэ жилийн жагсаалд шинэ төрлийн онцлог дөрвөн техник оролцсоны хоёр нь газраар, хоёр нь агаарт нисэхэд зориулагджээ. Жолоочийн шаардлагагүй буюу операторын тусламжтай үүргээ гүйцэтгэх Уран-6 болон Уран-9 танкууд нь овор хэмжээний хувьд харьцангуй жижиг болсон байна. “Уран 9”-ийг Москва дахь цэргийн дэвшилтэт зэвсэг үйлдвэрлэгч JSC 766 UPTK үйлдвэр зохион бүтээсэн бөгөөд энэхүү робот систем нь тагнуул хийх болон тагнуулын хэрэгслүүдэд гал нээн дэмжлэг үзүүлэхэд зориулагдан бүтээгдсэн учир байлдааны явцыг цаг хугацаанаас үл хамааран оператор төв рүү илгээх зориулалттай аж. Түүнчлэн, цаг агаарын ямар ч нөхцөлд нисэх

чадвартай Корсар нэртэй дроныг ч очигдрийн жагсаалаар анх удаа олонд танилцууллаа. Тус зэвсэг нь сонгогдсон байг хамгийн хурдан онилох хүчин чадалтайгаас гадна газарт байгаа цэргийн хүчинд гэрлээр дохио өгөх зэрэг давуу талтай гэнэ. Мөн удирдлагын төвөөсөө 100 км хүртэл зайд ажиллахаар зохион бүтээгдсэн байна. Өөр нэгэн онцлог нисэгч техник нь хоёр км хүртэлх өндөрт хөөрөх чадвартай, цагт 130 км цаг хурдлах алсын удирдлагатай нисгэгчгүй дрон “Катран” юм. Катран нь мөн л цаг агаарын бүхий л нөхцөлд мэдээ дамжуулах, тагнуулын журмаар ашиглагдах боломжтой. 120 кг хүртэлх ачааны даацтай гэдгээрээ ч давуу талтай байна.



Улаанбаатарт:



Өнөөдөр  
Өдөр 14  
Шөнө 6



Маргааш  
Өдөр 15  
Шөнө 2

## ӨДРИЙН ЗҮРХАЙ



ХАВРЫН АДАГ УЛААН ЛУУ  
САРЫН ШИННИЙ 25.  
ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ХАР  
БАР ӨДӨР

Үс засуулбал:

Нүд бүрэлзэн улцайна.

Наран ургах, шингэх:

05.24-20.16



Тухайн өдөр морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын абшиг авах, шинэ гэр ба байр авах, хараал, жатхыг буцаах, амьлуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, тангарагаа буцаахад сайн. Золинг гаргах, бомбын үйл, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, моргой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

## ӨДРИЙН ХҮН



### Б.ӨНӨРТОГТОХ

Аугаа эх орны дайны ялалтын 73 жилийн ой өчигдөр тохиолоо. Зөвлөлт, Монголын ард түмний хамтын ялалтын түүхэн энэ ой бол ахмад дайчид, цэрэг эрсээрээ бахархаж, залуу үе, нийт ард түмнээрээ бахархан дурсах ёстой өдөр юм. Тиймдээ ч хоёр дайнд оролцож, ОХУ-ын ахан дүүстэй мөр зэрэгцэн Эх орны дайнд тулалдаж, тусгай үүрэг гүйцэтгэж явсан ахмад дайчин, чөлөөнд буй хурандаа Ц.Алтангэрэлийг энэ удаагийн “Өдрийн хүн”-ээр онцлохыг хүслээ. Ц.Алтангэрэл нь Эх орны дайны үед ОХУ-ын Москва хотноо суралцаж байсан түүхтэй. Улмаар, дайн эхэлсний дараа хичээлдээ суухын хажуугаар Улаан армийн сапёрын ангийн тусламжтайгаар танкийн саад босгож, хамгаалалтын нуувч үхдэг байжээ. Харин сургуулийнх нь 800 гаруй багш, оюутан фронтод явах үед фронт



# ТАКСИЧИД АА, МАШИНАА УГААЧИХАЖ БАЙ Л ДАА

### Н.ПУНЦАГБОЛД

Улаанбаатар хотод машин унасан болгон таксинд явж, хүмүүсийн хэлдгээр халтуур хийдэг. Нийтийн тээвэр, зөвшөөрөлтэй компанийн үйлчилгээ хөгжжөөгүй болохоор тэр орон зайг нөхөхгүй гээд ч яах билээ. Тэгээд ч таксинд явж, амьжиргаандаа нэмэрлэж байгааг нь буруутгах аргагүй. Гэвч эрхэм жолооч нар минь, машинаа сайхан угаачихаж бай л даа. Цэвэрхэн, сайхан машинд хүн бүр дуртай сууна. Ороод суухад сайхан үнэртэй, цэвэрхэн,

аятайхан такси байвал бүр ч сэтгэл хангалуун байна биз дээ. Гэтэл зарим таксичид машинаа угаахаа мартчихдаг. Гадна талдаа ч халтар, заваан. Ороод суухад хувцас хир болгomoор тоос шороотой. Үнэр, танар гэж авах юмгүй машинтай үйлчилгээ үзүүлэх гээд явж байдаг. Машинаа дотор, гаднагүй угаалгахад тийм ч үнэтэй биш. 15 хоногтоо нэг сайн угаалгачихаад, бусад үед нь арчаад яваад байхад бохирдохгүй шүү дээ. Орчин цагт иргэд соёлтой, боловсон үйлчилгээг хүсдэг болчихсон. Тоос шороо болсон муухай машинтай ирж зогсоод, хаашаа явах гэж асуудаг хүмүүсийн

машинд суухаасаа суухгүй нь ойлгомжтой. Тиймээс нэгэнт л үйлчилгээ үзүүлж байгаа юм чинь үйлчлүүлэгчээ хаан гэж боддоггүй юм гэхэд ядаж л өмссөн хувцсыг нь бохирдуулахгүй машинтай таксинд яв л даа. Суудлын бүрээс сардаа нэг угаачихаад, хааяа нэг машинаа угаалгачихаад явахад төлж дийлэхээргүй их мөнгө хэрэг болохгүй нь ойлгомжтой. Соёлтой үйлчилгээ, эелдэг харилцаа зөв энергийг түгээнэ. Цөөхөн монголчууд минь, бие биеэ хүндтээд сурчихмаар байх юм.



“Нo.н” бyланд тaвмaй нopил

Ñ-Í ÓĖÑÛÍ Õ-ÉÒÝÍ ÓÓĖÛÍ ÀÈ×ÈĀ

Түрүүч нь №088 (4938)  
Үргэлжлэл.

Одоо би харин хорлох болмуй хэмээн дотроо сэтгэж өвсний байшинд орж будаа хүлээн суув. Үүнд ер будаа ирж авчирч өгсөнгүй тул дахин дахин Гүй өгүүлрүүн: Чамайг явснаас хойш хоёр хэмээсэнд эх нь өгүүлрүүн: Чамайг явснаас хойш хоёр нүд сохров. Гагцхүү дүү Ли Фү чинь өдөр бүр нэгэн ваар хоол өгдөг чухам ямар хоолыг мэдэхгүй хэмээсэнд Ли Гүй өгүүлрүүн: Дүү Ли Фү хоол өгч байсан нь сайн. Эдүгээ бий харьж ирсэн учир болбоос эмгэн эх таныг аваачихаар ирэв хэмээсэнд эх нь өгүүлрүүн: Чн өдий олон жил болтол хаана байж ямар зэрэг хэргэм олов хэмээсэнд Ли Гүй дотроо бодож өгүүлрүүн: Энэ Лян Шань. Пү хэмээхийг сонсвол хэрхэвч явахгүй, эдүгээ ноён болов хэмээн хуурч аваачваас хэрхэвч үзмүй хэмээн сэтгээд Жань Жоу-д Жань-ий ноён болов хэмээсэнд эх нь маш баярлан сайн сайн хэмээсэнд Ли Гүй өгүүлрүүн: Эх одоо явъя. Би нь алба хэргийн чөлөө авч ирсэн хоног удааширваас над басхүү ял гэм ирэх хэмээсэнд эх нь өгүүлрүүн: Чи дүү Ли Фү-ээ баахан хүлээж учраад явбаас сайн хэмээсэнд Ли Гүй эр лүгээ учирсан эссэн гайгүй би хурдан нэгэн тэрэг олж одоо явсугай хэмээсэн үүнд эхээ аваад гарах хэмээтэл, дүү нь нэгэн ваар хоол эхдээ авч орж ирээд яв цав үүдний дотор тохиолдов.

Тэндээс тэр дүү нь өгүүлрүүн: Ах чи нь хэдийд ирэв. Бас ямар хэрэг дэгдэхээр санаж хөгшин эх бид хоёрыг зовоомуй хэмээсэнд Ли Гүй өгүүлрүүн: Би нь Жань Жоу-д түшмэл сууж ноён болов. Иймийн тул эхээ аваачиж өргөх хэмээн ирэв хэмээсэнд дүү нь өгүүлрүүн: Худал хэлэх нь маш мэргэн чи Жань Жоу-д ноён суух байтугай урвасан ялт хэмээн цол гарч газар оронд чамайг барих хэмээн бичиг нааж хүмүүн бүрд зарласан атал бас ноён хэмээн биеэ өргөж хуурмагаар хөгшин эхийг минь

“...Хий Сюайнь Жан хэмээх төмөр үхэр цолтой хэн үл надаас аймуй. Өчүүхэн чи харин үг хэлэлгүй надад энэ авч яваа ваадантай юмаа хүргэж өгөөд амиа гуйваас зохих бөлгөө...”

цөлөх буюу. Эмгэн ээж үүний үгийг бүү итгэ. Эдүгээ би учрыг сайтар нээн хэлж өгье. Энэ Ли Гүй угаас хүмүүн алж оргон гарсны хойно үүний төлөө би басхүү дөнгө амаж маш их зүдэрснийг та үл мэдэх буюу. Гагцхүү буянтны хүчээр гарсан билээ. Эдүгээ сонсвоос энэ гайхал Жань Жоу-д очоод Сүн Жян ь хэмээх хүмүүн лүгээ санаа урваж түүн лүгээ журмын ах дүү болж бас Дай Жүн хэмээх нэгэн гянданы дарга нартай нам нийлж Лян Шань уулын урвасан хулгай нар лугаа цаазаар аваачих их ялт Сүн Жян , Дай Жүн хоёрыг булаан авч Жань Жоу-г түйвээсэн муу ялт нар хэмээн одоо улсын яам бүхий газар эднийг барихаар бичиг тараасан бөгөөтөл ноён суув хэмээн худал хэлэв. Харин Лянь Шань-д урвасан муу хулгай билээ. Ээж бүү очигтун хэмээсэнд, Ли Гүй өгүүлрүүн: Дүү чи бүү уурлагтун. Өчүүхэн ах чинь эмгэн ээжийг аваачих ба басхүү чиний биенийг авч Лян Шань ууланд очиж бие амар жаргая хэмээсэн билээ хэмээсэнд дүү өгүүлрүүн: Чиний урвасан хулгайг дагаж журам өвдэх ёс хаана хэмээн авч явсан ваартай юмаа газарт хаяж шууд уурлан явж өөрийн байх газар очив. Үүнд Ли Гүй ийн сэтгэрүүн: Чи үл явах аваас байгтун. Би хөгшин эхээ үүрч явбаас барав. Гагцхүү чамд амь зугтах мөнгө тавин ланг чиний гэрт үлдээж хөрөнгө болгоё хэмээн ваадангаас мөнгө тавин ланг гаргаж авдар дээр тавиад эхээ үүрэн шууд хаалга гарч нарийн зам хөөв. Үүнийг үл өгүүлэн өгүүлэх нь, тэр Ли Да Фү дүү нь өөрийн байдаг газар очиж эл учрыг хэлж арван хэдэн хүмүүн авч ирээд Ли гүй-г барих хэмээн ирээд гэртээ орвоос эх нь үгүй Ли Гүй бас үгүй үүнд аргагүй ийш тийш хашаандаа эрэвч олсонгүй тул одоо явж хэмээн хойноос хөөе гэтэл тэр тэнэг намайг хэрхэвч гэдрэг буцаагүй дээр басхүү уур нь хүрвээс харин миний амь

“...Ли Гүй гадагш гарч ийш тийш харж байваас нэлээд холоос нэгэн сайн эр бололтой хүмүүн өрөөсөн хөл доголон мэт хазгар явж ирэв...”



Nuclear Ganaa @ganaa23mn

Цэдэнбал даргын хөшөөнд цэцэг өргөсөнгүй нтр гэж өнчин хүүхдийн комплекстэй өчүүхэн улс төр битгий хий малнууд минь... та нар шиг шалтгаан үр дагаварын талаар өчүүхэн ч ойлголтгүй новшнуудаас болж ажилсаг хөдөлмөрч, тусч, цайлган Увсын ард түмний минь талаар буруу ойлголт үүсдэг.



Н.Одонгяа @Odongua

охины маань урлагийн үзлэг болов, гоцлол номер огт бсангүй. нийтээрээ хөгжимдөж, дуулж, бүжиглэж үзүүлэв. Эрх тэгш байна гэдэг нь энгийн зүйлд ч оролцоог жигд бий болгохоос л эхэлдэг!!!



Аанхяа @Aanxaa

3 настай ач хүүдээ дан пороро ундаа өгдөг өвөө эмээ хоёртой таарч билээ. Аав ээж нь гадаадад. Өнөөх нь ус ч уудаггүй, ууртай, ээвхнй царайтай, пороро л уудаг, авдраар нь авчихсан. Тэр өвөө эмээ одоо магад эмч нарыг, монголын эрүүл мэндийн системийг муулна



Erdenebileg Dulguun

Энэ хоёр цагдаа дөнгөж сая хүний амь аварлаа. 70 эргэм настай өвөө ухаан алдаж унасан байдалтай байхад нь багажнаасаа анхны тусламжын хайрцаг наргаж ирээд, түргэн тусламж ирэхээс өмнө амжиж сэргээж чадлаа! Мундаг байна!